

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/087/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас:99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН 13 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ЖАНАРГУЛ ТАНАА**

2024.02.21 № 78
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг нь 2024 онд 890.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 706.0 сая төгрөг зарцуулж, 79.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832502000092

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>147,963,435.79</u>	<u>252,615,512.62</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	114,383,427.26	184,883,933.26
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	114,383,427.26	184,883,933.26
3121	Төгрөг	114,383,427.26	184,883,933.26
31211	Төрийн сангийн харилцах	114,383,427.26	184,883,933.26
33	АВЛАГА	-	345,576.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	345,576.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,580,008.53	67,386,003.36
354	Хангамжийн материал	33,580,008.53	67,386,003.36
35420	Аж ахуйн материал	436,700.00	4,299,700.00
35440	Түлш, шатах тослох материал	3,293,200.79	1,673,850.29
35460	Хүнсний материал	6,296,272.74	22,990,559.07
35470	Бусад хангамжийн материал	23,553,835.00	38,421,894.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>267,721,259.41</u>	<u>331,079,192.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	267,721,259.41	331,079,192.07
392	Биет хөрөнгө	252,309,601.40	315,809,858.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	269,459,018.00	271,259,018.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,101,999.92)	(31,626,012.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,074,055.00	68,568,222.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,059,405.01)	(11,097,253.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,230,312.50	38,523,712.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,322,379.17)	(19,847,829.17)
39217	Ном	30,000.00	30,000.00
393	Биет бус хөрөнгө	15,411,658.01	15,269,334.05
39301	Програм хангамж	2,149,239.00	2,149,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(761,580.99)	(903,904.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,024,000.00	14,024,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>415,684,695.20</u>	<u>583,694,704.69</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>13,530,962.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	13,530,962.00
413	Өглөг	-	13,530,962.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	350,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	9,317,962.00
4136	Бусад өглөг	-	3,863,000.00

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,863,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	415,684,695.20	570,163,742.69
51	Засгийн газрын хувь оролцоо	415,684,695.20	570,163,742.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,024,000.00	14,024,000.00
51101	Өмч: - төрийн	14,024,000.00	14,024,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	401,660,695.20	556,139,742.69
51210	Өмнөх үеийн үр дүн	401,660,695.20	401,660,695.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	154,479,047.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	415,684,695.20	583,694,704.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	593,869,739.00	860,431,261.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,223,639.00	83,898,661.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,223,639.00	83,898,661.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,223,639.00	83,898,661.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,223,639.00	83,898,661.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,646,100.00	776,532,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,023,200.00	759,211,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,023,200.00	759,211,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,622,900.00	17,321,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,622,900.00	17,321,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	470,873,854.72	705,952,213.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,873,854.72	705,952,213.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,873,854.72	705,952,213.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,465,731.91	524,503,151.00
210101	Үндсэн цалин	232,611,773.91	404,652,134.00
210102	Нэмэгдэл	93,613,975.00	112,296,327.00
210104	Урамшуулал	16,239,983.00	7,554,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,722,790.00	72,612,617.00
210201	Тэтгэврийн даатгал	33,983,190.00	47,103,417.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,935,500.00	6,377,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,148,600.00	3,188,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	785,800.00	3,188,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,869,700.00	12,754,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,745,400.00	27,383,912.50
210301	Гэрэл, цахилгаан	3,086,900.00	4,354,662.00
210302	Түлш, халаалт	11,493,500.00	17,029,250.50

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	165,000.00	1,000,000.00
210304	Байрны түрээс	-	5,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,234,250.00
210401	Бичиг хэрэг	-	2,234,250.00
2105	Нормативт зардал	43,195,928.00	54,424,963.67
210502	Хоол, хүнс	43,195,928.00	54,424,963.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	798,900.00
210604	Урсгал засвар	500,000.00	798,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	513,000.00	1,998,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	513,000.00	1,998,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,731,004.81	21,996,219.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,010,800.00	8,624,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,682,200.00	5,603,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,038,004.81	7,768,319.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>122,995,884.28</u>	<u>154,479,047.49</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>122,995,884.28</u>	<u>154,479,047.49</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>583,646,100.00</u>	<u>776,532,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>583,646,100.00</u>	<u>776,532,600.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,023,200.00	759,211,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,023,200.00	759,211,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,622,900.00	17,321,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,622,900.00	17,321,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>471,319,734.00</u>	<u>704,796,694.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>471,319,734.00</u>	<u>704,796,694.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>471,319,734.00</u>	<u>704,796,694.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,929,594.00	524,498,727.00
210101	Үндсэн цалин	237,908,394.00	363,022,584.00
210102	Нэмэгдэл	93,613,975.00	149,798,243.00
210104	Урамшуулал	13,407,225.00	11,677,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,722,790.00	72,612,617.00
210201	Тэтгэврийн даатгал	33,983,190.00	47,103,417.00

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	3,935,500.00	6,377,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,148,600.00	3,188,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	785,800.00	3,188,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,869,700.00	12,754,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,122,900.00	16,821,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,516,900.00	3,561,600.00
210302	Түлш, халаалт	13,806,000.00	11,760,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	48,752,850.00	71,119,250.00
210502	Хоол, хүнс	48,752,850.00	71,119,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,200.00	1,991,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,200.00	1,991,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,691,400.00	17,253,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,890,700.00	11,284,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,700.00	5,968,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>112,326,366.00</u>	<u>71,735,906.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,235,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,235,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,235,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,235,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>(1,235,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	112,326,366.00	70,500,506.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		114,383,427.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	114,383,427.26	184,883,933.26

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,024,000.00	-	278,664,810.92	292,688,810.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,024,000.00	-	278,664,810.92	292,688,810.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	122,955,844.28	122,955,844.28
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,024,000.00	-	401,620,655.20	415,644,655.20
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,024,000.00	-	401,620,655.20	415,644,655.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,024,000.00	-	401,620,655.20	415,644,655.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	154,479,047.49	154,479,047.49
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,024,000.00	-	556,099,702.69	570,123,702.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,057,061.26		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,703,200.00	471,319,734.00	890,916,000.00	706,032,094.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,703,200.00	471,319,734.00	890,916,000.00	706,032,094.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,703,200.00	471,319,734.00	890,916,000.00	706,032,094.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,423,800.00	344,929,594.00	696,283,200.00	524,498,727.00
210101	Үндсэн цалин	271,780,500.00	237,908,394.00	497,513,100.00	363,022,584.00
210102	Нэмэгдэл	160,583,800.00	93,613,975.00	186,412,100.00	149,798,243.00
210104	Урамшуулал	14,059,500.00	13,407,225.00	12,358,000.00	11,677,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,153,400.00	49,722,790.00	82,069,700.00	72,612,617.00
210201	Тэтгэврийн даатгал	38,864,900.00	33,983,190.00	55,808,700.00	47,103,417.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,572,700.00	3,935,500.00	6,564,300.00	6,377,300.00

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,658,400.00	3,148,600.00	3,282,700.00	3,188,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	913,300.00	785,800.00	3,282,700.00	3,188,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,144,100.00	7,869,700.00	13,131,300.00	12,754,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,122,900.00	18,122,900.00	16,821,600.00	16,821,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,516,900.00	3,516,900.00	3,561,600.00	3,561,600.00
210302	Түлш, халаалт	13,806,000.00	13,806,000.00	11,760,000.00	11,760,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	54,211,500.00	48,752,850.00	72,904,400.00	71,119,250.00
210502	Хоол, хүнс	54,211,500.00	48,752,850.00	72,904,400.00	71,119,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,200.00	600,200.00	1,991,200.00	1,991,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,200.00	600,200.00	1,991,200.00	1,991,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,691,400.00	8,691,400.00	20,345,900.00	18,488,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,890,700.00	6,890,700.00	14,377,100.00	12,519,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,800,700.00	1,800,700.00	5,968,800.00	5,968,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	585,703,161.26	583,646,100.00	890,916,000.00	776,532,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	565,023,200.00	565,023,200.00	759,211,000.00	759,211,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	565,023,200.00	565,023,200.00	759,211,000.00	759,211,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,622,900.00	18,622,900.00	17,321,600.00	17,321,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	18,622,900.00	18,622,900.00	17,321,600.00	17,321,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,057,061.26	-	114,383,400.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,057,061.26	-	114,383,400.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,057,061.26		114,383,427.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		114,383,427.26		184,883,933.26

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус цэцэрлэг нь 2024 онд ""Багшаа чадваржуулан хүүхэд нэг бүрийн

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хөгжлийг дэмжиж, бие даасан хүн болгон төлөвшүүлнэ" гэсэн зорилготой ажиллаж, 10 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цэцэрлэгчийн эрхлэгчийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/21 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 168.0 сая төгрөгөөр буюу 40.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	114,383.43	184,883.93	70,500.51

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Авлага	-	345.58	345.58
Урьдчилгаа			
Бараа материал	33,580.01	67,386.00	33,805.99
Үндсэн хөрөнгө	267,721.26	331,079.19	63,357.93
Нийт хөрөнгө	415,684.70	583,694.70	168,010.01
Өр төлбөр	-	13,530.96	13,530.96
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	415,684.70	570,163.74	154,479.05
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	415,684.70	583,694.70	168,010.01

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 184.9 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 70.5 сая төгрөгөөр өссөн байна. Цалингийн төсвөөс 172.7 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээс 9.6 сая төгрөг, хүүхдийн хоолны зардлаас 1.8 сая төгрөг, бараа, үйлчилгээний зардлаас 1.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Авлага данс оны эцэст 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материал данс оны эцэст 67.4 сая төгрөг болж, оны эхнээс 33.8 сая төгрөгөөр өссөн байна. Хүнсний материал 23.0 сая төгрөгийн, түлш 1.7 сая төгрөгийн, аж ахуйн материал 4.3 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 38.4 сая төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 331.1 сая төгрөг болж, 63.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй хүлээн авсан 69.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 19.5 сая төгрөгийн хөрөнгө актлагдаж, үндсэн хөрөнгөд 7.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эцэст 13.5 сая төгрөг болж, оны эхнээс 13.5 сая төгрөгөөр өссөн байна. Байрны түрээсийн 5.0 сая, гэрэл цахилгааны 9.3 сая, түлш халаалтын 0.8 сая, байрны урсгал засварын 3.9 сая төгрөгийн өглөгтэй гарчээ. Энэ нь салбар бүлэг оны эцэст нээгдсэн боловч орон нутгийн төсвийн санхүүжилтэнд тодотгол хийж өгөөгүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 570.2 сая төгрөг болж, 154.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 154.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 483.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 19.2 сая төгрөг, нийт зарлагыг 502.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 477.3 сая төгрөгөөр хянаж, 6.4 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 396.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 873.6 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 17.3 сая төгрөгөөр хянаж, 1.9 сая төгрөгөөр бууруулан баталсан ба тодотгол хийгдээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 873.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 17.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 890.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 759.2 сая, орон нутгийн төсвөөс 17.3 сая, нийт 776.5 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 114.4 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 706.0 сая төгрөг болж, 79.2 хувийн биелэлттэй, 184.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ төгрөгөөр/						
д/д	Арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хүүхэд хамгаалал	80233	966,200.00	966,200.00	0.00	100.0
2	Эрүүл мэндийг дэмжих	81605	1,308,300.00	1,308,300.00	0.00	100.0
3	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	81807	72,904,400.00	71,119,250.00	-1,785,150.00	97.6
4	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	2,395,400.00	2,395,400.00	0.00	100.0
5	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	81823	1,308,300.00	1,308,300.00	0.00	100.0
6	Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	81834	793,718,800.00	610,620,044.00	-183,098,756.00	76.9
7	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81835	993,000.00	993,000.00	0.00	100.0
	Улсын төсвийн санхүүжилтийн дүн		873,594,400.00	688,710,494.00	-184,883,906.00	78.84
	Нийтлэг үйлчилгээ ОН	80111	17,321,600.00	17,321,600.00	0.00	100.0
	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн дүн		17,321,600.00	17,321,600.00	0.00	100.0
	Нийт дүн		890,916,000.00	706,032,094.00	184,883,906.00	79.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 22.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар баталсан хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг баримтлан ажиллаж байна.

Тус цэцэрлэгийн 1-11 дүгээр сарын цалин олгох хүснэгтээр 27 хүнд цалин хөлс олгосон байна. Аймгийн Засаг даргын 2024 оны А/803, А/1127 захирамжаар цэцэрлэгийн дэргэдэх салбарыг 3 бүлэгтэй байгуулж, 18 орон тоо нэмж, 45 болгон баталсан байна. Гүйцэтгэлээр 4 орон тоо /хоол зүйч, сэтгэл зүйч, цагаан хэрэглэл угаагч, жижүүр тус бүр 1/ дутуу байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэг нь 2024 онд 102.7 сая төгрөгийн бараа материал, 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 470.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай /өмнөх

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

оноос улсын төсвийн санхүүжилт 34.4 хувиар өссөн/ гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 705.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 5 /Дараа жилийн төсвийн төсөл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-эдийн засгийн ангилал/ мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2 /Худалдан авах ажиллагааны тайлан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт/ мэдээлэл оруулаагүй зөрчил илрэв.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн, хугацаанд нь оруулж байх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд, дансны код сонголт, бичилт, ангилалтай холбоотой 51.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн ба 51.6 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах зөвлөмж хэрэгжээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авалтын төлөвлөлт, хэрэгжилт, цалингийн нэмэгдлүүдийн асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 95.8 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 95.8 төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 95.8 сая төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд 95.8 төгрөгийн залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд: *Залруулсан алдаа*:

- Цалингаас суутгах төлбөр болон ээлжийн амралтын олговрын дансны бичилтийг буруу хийснийг Ерөнхий журналд залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

5.2 Албан шаардлага

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаартай “Төсвийн шууд захирагч нарт” албан бичгээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшууллыг олгож болно гэснийг үндэслэн, сургуулийн захирлын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар 4.0 сая төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

2.Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй байна.

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заалт, ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулалыг холбогдох хууль, журам зөрчиж, тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх., ур чадварын нэмэгдлийг холбогдох шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгож байх талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Цэцэрлэг нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /хоол хүнс 71.1 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 1.2 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 95,809,725.00

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсний бичилт буруу хийсэн.	1	95,809.7			1	95,809.7	1	95,809.7				

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн	1	95,809.7			1	95,809.7	1	95,809.7				
------------	----------	-----------------	--	--	----------	-----------------	----------	-----------------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал, ур чадварын нэмэгдэлтэй холбоотой	1	4,034.0			1	4,034.0						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй.	1	0					1	0				
Дүн	2	4,034.0			1	4,034.0	1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. 2 мэдээлэл байршуулаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								

Хөдөлмөрийн тухай хууль-4.1.10, 4.1.18, 20.1, 21.1, 21.5, 22.4, 26.4, 26.9, 48.1, 48.2, 18.3, 71.1, 76.4, 79.2, 80.4, 81.6, 83.4, 123.3, 123.9, 132.1, 142.5, 145.4, 148.1, 148.2

1. Боловсролын ерөнхий хууль-13.2.8, 17.2, 28.2.8, 31.1.2
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчлэгдсэн/
3. Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол /Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай/
4. Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол /2024 оны 39 дүгээр тогтоолыг хүчингүй болгох тухай/
5. Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол
6. Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол /албан тушаалын зэрэглэл, жагсаалт батлах тухай/
7. Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол /Төрийн албаны заримт албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, 2024 оны 4 дүгээр сарын 1-нээс мөрдөнө/
8. Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;
9. Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 17-ны 162 дугаар тогтоол Жагсаалт батлах тухай (ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээ)
10. Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны 39 дүгээр тогтоол Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай (сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ)
11. ~~Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 29-ний 237 дугаар тогтоол Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох~~
12. Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны 104 дүгээр тогтоол Журам батлах тухай (багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох)

Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13. Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 6-ны 103 дугаар тогтоол Журам батлах тухай (багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх)
14. Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 1-ний 193 дугаар тогтоол Журамд өөрчлөлт оруулах тухай /2024 оны 3 дугаар сарын 6-ны 104 дүгээр тогтоолд өөрчлөлт/
15. Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний 1/1536 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичиг /Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай байгуулсан цалин хөлстэй холбоотой асуудлаарх гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх талаар/